



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 429

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас  
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 4,190,500.00 (дөрвөн сая нэг зуун ерэн мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 2 дахь дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Стандарт, хэмжил зүйн газрын дарга Г.Гантөмөр, Өвөрхангай аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002281



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 09 ны өдрийн  
109 дугаар тогтоолын хавсралт

Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн  
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, сэлбэгээр худалдах автомашин, механизмын жагсаалт

Д/д	Автомашин <span>ы</span> марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэлбэгээр ашигласнаас олох орлогын хэмжээ (төгрөг)
1	"Ландкрийзер-80", 00-04 ӨВА, суудлын, FZJ800025968	1993/2006	345568	4,190,500.00	4,190,500.00	0	0	800,000.00
	Нийт дүн			4,190,500.00 (дөрвөн сая нэг зуун ерэн мянга таван зуун)	4,190,500.00 (дөрвөн сая нэг зуун ерэн мянга таван зуун)			800,000.00 (найман зуун мянган)